

“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2018 оны 10 дугаар сарын 24-ны өдөр

№ 18/19

Улаанбаатар хот

Зээлийн эх үүсвэр татан төвлөрүүлэх эрх олгох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.16 дахь хэсэг, 80 дугаар зүйл, 87 дугаар зүйлийн 87.1 дэх хэсэг, 88 дугаар зүйлийн 88.1 дэх хэсэг, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани” гэх)-ийн дүрмийн 9.6.4, 9.6.19 дэх хэсгийг тус тус үндэслэн Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс **ТОГТООХ нь:**

1. ЛэндМН ББСБ ХК-ийн зээлийн үйл ажиллагааг санхүүжүүлэхэд зориулан Голомт банкнаас дараах нөхцөлийн дагуу гэрээ байгуулж зээл авах эрхийг Гүйцэтгэх захирал (Б.Дэлгэржаргал)-д олгосугай.

Зээлийн хэмжээ	5 (таван) тэрбум төгрөг хүртэл
Зээлийн хэлбэр	Зээлийн шугам
Зээлийн хугацаа	3 хүртэл жил
Зээлийн хүү	Голомт банктай тохиролцсон хүү
Зээл олголтын шимтгэл	1 хүртэл хувь
Эргэн төлөх нөхцөл	Голомт банкнаас тогтоосон нөхцөлийн дагуу
Нөөцлөн баталгаажуулсан шимтгэл	Жилийн 2%-4%
Барьцаа хөрөнгө /Сонголтоор/	Дансны орлого; ЛэндМН ББСБ ХК-ийн зээлийн багц буюу шаардах эрх; Анд Системс ХХК-ийн батлан даалт, Хувьцаа.

2. Зээлийн шугам нээлгэж, зээлийн санхүүжилт авах асуудлаар Голомт банкинд хүсэлт гаргах, зээлийн судалгаанд шаардлагатай мэдээлэл, материалыг бүрдүүлж, хүргүүлэх, зээлийн нөхцөлийг энэхүү тогтоолд заасан нөхцөлийн хүрээнд хэлэлцэн тохирох, Зээлийн болон Барьцааны гэрээ байгуулах, гэрээнд гарын үсэг зурах эрхийг Гүйцэтгэх захирал (Б.Дэлгэржаргал)-д олгосугай.
3. Голомт банктай байгуулсан Зээлийн гэрээ, санхүүжилтын нөхцөлийг Төлөөлөн Удирдах Зөвлөлд эргэн тайлагнахыг Гүйцэтгэх захирал (Б.Дэлгэржаргал)-д үүрэг болгосугай.

4. Татан төвлөрүүлсэн мөнгөн хөрөнгийг СЗХ-оос олгогдсон тусгай зөвшөөрлийн дагуу эрхэлж буй ЛэндМН ББСБ ХК-ийн зээлийн үйл ажиллагаанд зарцуулахыг Гүйцэтгэх захирал (Б.Дэлгэржаргал)-д үүрэг болгосугай.



ТУЗ-ИЙН ДАРГА:

..... /О.БОЛДБААТАР/

ТУЗ-ИЙН ГИШҮҮД:

..... /С.ЭНХ-АМГАЛАН/

..... /С.БОРГИЛ/

..... /Б.ГАНТУЛГА/

..... /Б.ДЭЛГЭРЖАРГАЛ/

..... /Ж.ЖАРГАЛСҮРЭН/

..... /В.БАЯРСАЙХАН/

..... /Н.ЦЭВЭГМИД/

“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2018 оны 10 дугаар сарын 24-ны өдөр

№ 18/20

Улаанбаатар хот

Зээлийн эх үүсвэр татан төвлөрүүлэх эрх олгох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.16 дахь хэсэг, 80 дугаар зүйл, 87 дугаар зүйлийн 87.1 дэх хэсэг, 88 дугаар зүйлийн 88.1 дэх хэсэг, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани” гэх)-ийн дүрмийн 9.6.4, 9.6.19 дэх хэсгийг тус тус үндэслэн Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс **ТОГТООХ нь:**

1. ЛэндМН ББСБ ХК-ийн зээлийн үйл ажиллагааг санхүүжүүлэхэд зориулан Худалдаа Хөгжлийн Банкнаас дараах нөхцөлийн дагуу гэрээ байгуулж зээл авах эрхийг Гүйцэтгэх захирал (Б.Дэлгэржаргал)-д олгосугай.

Зээлийн хэмжээ	1 (нэг) тэрбум төгрөг хүртэл
Зээлийн хэлбэр	Овердрафт
Зээлийн хугацаа	1 хүртэл жил
Зээлийн хүү	ХХБ-тай тохиролцсон хүү
Зээл олголтын шимтгэл	0.3 хүртэл хувь
Эргэн төлөх нөхцөл	Хүү болон үндсэн зээлийг сар бүр
Барьцаа хөрөнгө	Дансны орлого

2. Овердрафт нээлгэж, зээлийн санхүүжилт авах асуудлаар Худалдаа хөгжлийн банкинд хүсэлт гаргах, зээлийн судалгаанд шаардлагатай мэдээлэл, материалыг бүрдүүлж, хүргүүлэх, зээлийн нөхцөлийг энэхүү тогтоолд заасан нөхцөлийн хүрээнд хэлэлцэн тохирох, Зээлийн болон Барьцааны гэрээ байгуулах, гэрээнд гарын үсэг зурах эрхийг Гүйцэтгэх захирал (Б.Дэлгэржаргал)-д олгосугай.
3. Худалдаа Хөгжлийн Банктай байгуулсан Овердрафтын буюу зээлийн гэрээ, санхүүжилтын нөхцөлийг Төлөөлөн Удирдах Зөвлөлд эргэн тайлагнахыг Гүйцэтгэх захирал (Б.Дэлгэржаргал)-д үүрэг болгосугай.

4. Татан төвлөрүүлсэн мөнгөн хөрөнгийг СЗХ-оос олгогдсон тусгай зөвшөөрлийн дагуу эрхэлж буй ЛэндМН ББСБ ХК-ийн зээлийн үйл ажиллагаанд зарцуулахыг Гүйцэтгэх захирал (Б.Дэлгэржаргал)-д үүрэг болгосугай.

ТУЗ-ИЙН ДАРГА:



ТУЗ-ИЙН ГИШҮҮД:

...../С.ЭНХ-АМГАЛАН/

...../С.БОРГИЛ/

...../Б.ГАНТУЛГА/

...../Б.ДЭЛГЭРЖАРГАЛ/

...../Ж.ЖАРГАЛСҮРЭН/

...../В.БАЯРСАЙХАН/

...../Н.ЦЭВЭГМИД/

“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2018 оны 10 дугаар сарын 24-ны өдөр

№ 18/21

Улаанбаатар хот

Зээлийн эх үүсвэр татан төвлөрүүлэх эрх олгох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.16 дахь хэсэг, 80 дугаар зүйл, 87 дугаар зүйлийн 87.1 дэх хэсэг, 88 дугаар зүйлийн 88.1 дэх хэсэг, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани” гэх)-ийн дүрмийн 9.6.4, 9.6.19 дэх хэсгийг тус тус үндэслэн Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс **ТОГТООХ нь:**

1. ЛэндМН ББСБ ХК-ийн зээлийн үйл ажиллагааг санхүүжүүлэхэд зориулан Бичил Санхүүгийн Хөгжлийн Сангаас дараах нөхцөлийн дагуу гэрээ байгуулж зээл авах эрхийг Гүйцэтгэх захирал (Б.Дэлгэржаргал)-д олгосугай.

Зээлийн хэмжээ	1 (нэг) тэрбум төгрөг хүртэл
Зээлийн хэлбэр	Зээл
Зээлийн хугацаа	2 хүртэл жил
Зээлийн хүү	Жилийн 6 хувь
Зээл олголтын шимтгэл	БСХС-ийн нөхцөлийн дагуу
Эргэн төлөх нөхцөл	БСХС-ийн нөхцөлийн дагуу
Барьцаа хөрөнгө /Сонголтоор/	ЛэндМН ББСБ ХК-ийн зээлийн багц буюу шаардах эрх; Анд Системс ХХК-ийн батлан даалт, Хувьцаа.

2. Зээлийн санхүүжилт авах асуудлаар Бичил Санхүүгийн Хөгжлийн Санд хүсэлт гаргах, зээлийн судалгаанд шаардлагатай мэдээлэл, материалыг бүрдүүлж, хүргүүлэх, зээлийн нөхцөлийг энэхүү тогтоолд заасан нөхцөлийн хүрээнд хэлэлцэн тохирох, Зээлийн болон Барьцааны гэрээ байгуулах, гэрээнд гарын үсэг зурах эрхийг Гүйцэтгэх захирал (Б.Дэлгэржаргал)-д олгосугай.
3. Бичил Санхүүгийн Хөгжлийн Сантай байгуулсан Зээлийн гэрээ, санхүүжилтын нөхцөлийг Төлөөлөн Удирдах Зөвлөлд эргэн тайлагнахыг Гүйцэтгэх захирал (Б.Дэлгэржаргал)-д үүрэг болгосугай.

4. Татан төвлөрүүлсэн мөнгөн хөрөнгийг СЗХ-оос олгогдсон тусгай зөвшөөрлийн дагуу эрхэлж буй ЛэндМН ББСБ ХК-ийн зээлийн үйл ажиллагаанд зарцуулахыг Гүйцэтгэх захирал (Б.Дэлгэржаргал)-д үүрэг болгосугай.



ТУЗ-ИЙН ДАРГА:

..... /О.БОЛДБААТАР/

ТУЗ-ИЙН ГИШҮҮД:

..... /С.ЭНХ-АМГАЛАН/

..... /С.БОРГИЛ/

..... /Б.ГАНТУЛГА/

..... /Б.ДЭЛГЭРЖАРГАЛ/

..... /Ж.ЖАРГАЛСҮРЭН/

..... /В.БАЯРСАЙХАН/

..... /Н.ЦЭВЭГМИД/

“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2018 оны 10 дугаар сарын 24-ны өдөр

№ 13/22

Улаанбаатар хот

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн түр гишүүн томилох тухай

Компанийн тухай Монгол Улсын хуулийн 77 дугаар зүйлийн 77.5 дахь заалт, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани” гэх)-ийн дүрмийн 9.1 дэх хэсэг, Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Үйл ажиллагааны журмын 4.11 дэх хэсэг, ЛэндМН ББСБ ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2018 оны 10 сарын 24-ний өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөл (ТУЗ)-өөс **ТОГТООХ НЬ:**

1. ТУЗ-ийн гишүүн Дүгэрсүрэнгийн Бат-Очир нь ТУЗ-ийн гишүүнээс чөлөөлөгдөх хүсэлтээ гаргасан тул энэхүү тогтоол гарсан өдрөөр бүрэн эрхийг нь зогсоож Хувьцаа эзэмшигчдийн хурлаар тус гишүүнийг чөлөөлөгдсөнийг баталгаажуулахаар тогтоосугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдах хүртэл ТУЗ-ийн гишүүнээр Mathew Welch (Мэтью Вэлч) - ийг түр томилсугай.
3. Хууль тогтоомж, Компанийн дүрэм, ТУЗ-ийн үйл ажиллагааны журам, компанийн засаглалын журмуудыг мөрдөж ажиллахыг ТУЗ-ийн түр гишүүнд мэдэгдсүгэй.
4. ТУЗ-ийн түр томилогдсон гишүүн Mathew Welch (Мэтью Вэлч) -ийг ТУЗ-ийн дэргэдэх Эрсдлийн удирдлагын хорооны даргаар сонгосугай.
5. ТУЗ-ийн түр томилогдсон гишүүний талаархи мэдээллийг Хувьцаа эзэмшигчид, Санхүүгийн зохицуулах хороо, Хөрөнгийн биржид мэдэгдэхийг Гүйцэтгэх захирал (Б.Дэлгэржаргалд)-д үүрэг болгосугай.



ТУЗ-ИЙН ДАРГА

..... /О.БОЛДБААТАР/

“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2018 оны 10 дугаар сарын 24-ны өдөр

№ ... 18/23

Улаанбаатар хот

***Дотоод аудитын үйл ажиллагааны дүрэм,
заавар батлах тухай***

Компанийн тухай Монгол Улсын хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.13 дахь заалт, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани” гэх)-ийн дүрмийн 16.2 дахь хэсэг, Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Үйл ажиллагааны журмын 2.9.4 дэх хэсэг, ЛэндМН ББСБ ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2018 оны 10 сарын 24-ний өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөл (ТУЗ)-өөс **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн Дотоод аудитын үйл ажиллагааны журмыг энэхүү тогтоолын 1 дүгээр хавсралтаар, Дотоод аудитын үйл ажиллагааны зааврыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Дотоод аудитын үйл ажиллагааны журам, зааврыг мөрдөж ажиллахыг Дотоод аудитор /Б.Тэмүгэ/-т үүрэг болгосугай.
3. Дотоод аудитын үйл ажиллагааны журам, зааврын хэрэгжилтэнд хяналт тавих буюу дотоод хяналтын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороо /дарга Ж.Жаргалсүрэн/-нд үүрэг болгосугай.



“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2018 оны 10 дугаар сарын 24-ны өдөр

№ ... ¹⁸/24

Улаанбаатар хот

2018 оны санхүүгийн тайланд аудит хийх хөндлөнгийн аудитын байгууллагыг сонгох тухай

Компанийн тухай Монгол Улсын хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.10 дахь заалт, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани” гэх)-ийн дүрмийн 17 дугаар зүйл, 9.6.7 дахь заалт, ЛэндМН ББСБ ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2018 оны 10 сарын 24-ний өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс **ТОГТООХ НЬ:**

1. Эрнст энд Янг Монголия Аудит ХХК-ийг тус компанийн 2018 оны санхүүгийн тайланд аудит хийх хөндлөнгийн аудитын байгууллагаар сонгосугай.
2. Эрнст энд Янг Монголия Аудит ХХК-тай байгуулах гэрээний нөхцөлийг тодорхойлж, гэрээ байгуулж ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Аудитын хорооны дарга /Ж.Жаргалсүрэн/-д даалгасугай.
3. Аудитын байгууллагыг ажиллах нөхцөлөөр хангаж хамтран ажиллахыг Гүйцэтгэх захирал /Б.Дэлгэржаргал/-д үүрэг болгосугай.



ТУЗ-ИЙН ДАРГА:

..... /О.БОЛДБААТАР/

“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2018 оны 10 дугаар сарын 24-ны өдөр

№ 18/25

Улаанбаатар хот

*Сонирхлын зөрчилтэй хэлцэл
хийх зөвшөөрөл олгох тухай*

Компанийн тухай Монгол Улсын хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.17, 89 дүгээр зүйлийн 89.1 дэх хэсэг, 89.1.1 дэх заалт, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани” гэх)-ийн дүрмийн 9.6.20 дахь хэсэг, ЛэндМН ББСБ ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2018 оны 10 сарын 24-ний өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс **ТОГТООХ НЬ:**

1. “Анд Системс Тех” ХХК-тай LendMN програм хангамжийг ашиглах асуудлаар Зохиогчийн эрхийн бүтээл ашиглах гэрээ, Үйлчилгээний гэрээ байгуулж ажиллахыг Гүйцэтгэх захирал /Б.Дэлгэржаргал/ –д зөвшөөрсүгэй.



..... /О.БОЛДБААТАР/

“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2018 оны 10 дугаар сарын 24-ны өдөр

№ 18/26

Улаанбаатар хот

Хаалттай бонд гаргах, Их хэмжээний хэлцэл хийх зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2 дахь хэсэг, 76 дугаар зүйлийн 76.1.5, 76.1.16 дахь хэсэг, 80 дугаар зүйл, 87 дугаар зүйлийн 87.1 дэх хэсэг, 88 дугаар зүйлийн 88.1 дэх хэсэг, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани” гэх)-ийн дүрмийн 9.6.2, 9.6.19 дэх хэсэг, ЛэндМН ББСБ ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2018 оны 10 сарын 24-ний өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс **ТОГТООХ нь:**

1. Компаниас дараах нөхцөл бүхий хаалттай өрийн бичгийг гаргахаар шийдвэрлэсүгэй.
 - 1) **Нийт үнэ:** 1'750'000'000 (нэг тэрбум долоон зуун тавин сая) төгрөг хүртэл;
 - 2) **Хугацаа:** 1 (нэг) жил;
 - 3) **Хүү:** жилийн 17 (арван долоон) хувь хүртэл;
 - 4) **Хүү төлөх хугацаа:** 3 эсхүл 6 сар тутам;
 - 5) **Баталгаа:** Өөрийн хөрөнгө. Өөрийн бичиг нь ямар нэгэн компани аж ахуйн нэгжээс тусгайлан гаргасан баталгаагүй болно.
 - 6) **Хугацаанаас өмнө буцаан худалдан авах:** Компани нь өөрийн бичгийг хугацаанаас нь өмнө энд заасан нөхцөлөөр буцаан худалдан авах эрхтэй.
2. Үнэт цаасны компанитай хамтран ажиллах тохиолдолд гэрээ байгуулж, гэрээний дагуу гаргасан хаалттай өрийн бичгийн дүнгийн 2 (хоёр) хүртэлх хувьтай тэнцэх шимтгэлийг үнэт цаасны компанид төлөхийг зөвшөөрсүгэй.
3. Энэхүү тогтоолын 1 дэх хэсэгт заасан хаалттай өрийн бичгийг зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн хүрээнд гаргах асуудлаар Үнэт цаасны компанитай хамтран ажиллах, хаалттай өрийн бичгийн худалдан авагчийн судалгааг үнэт цаасны компанид хариуцуулж ажиллах, гэрээний Боломжит худалдан авагчтай дээр дурдсан нөхцөлөөр Худалдах, худалдан авах гэрээ байгуулах, гэрээнд гарын үсэг зурах эрхийг Гүйцэтгэх захирал (Б.Дэлгэржаргал)-д олгосугай.
4. Хаалттай өрийн бичиг гаргаснаар татан төвлөрүүлэх мөнгөн хөрөнгийг СЗХ-оос олгогдсон тусгай зөвшөөрлийн дагуу эрхэлж буй ББСБ-ын зээлийн үйл ажиллагаанд зарцуулахыг Гүйцэтгэх захирал (Б.Дэлгэржаргал)-д үүрэг болгосугай.



/О.БОЛДБААТАР/

“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2018 оны 10 дугаар сарын 24-ны өдөр

№ 18/24

Улаанбаатар хот

Төсөвт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Компанийн тухай Монгол Улсын хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь хэсэг, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани” гэх)-ийн дүрмийн 9.6.22 дахь хэсэг, ЛэндМН ББСБ ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2018 оны 10 сарын 24-ний өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн 18/10 дугаар тогтоолоор батлагдсан ““ЛэндМН ББСБ” ХК-ийн 2018 оны төсөв”-т энэхүү тогтоолын хавсралтад заасан нэмэлт, өөрчлөлтийг оруулсугай.
2. “ЛэндМН ББСБ” ХК-ийн 2018 оны төсөвт оруулсан нэмэлт, өөрчлөлтийг компанийн үйл ажиллагаанд мөрдөж ажиллахыг Гүйцэтгэх захирал /Б.Дэлгэржаргал/-д үүрэг болгосугай.



ТУЗ-ИЙН ДАРГА:

[Handwritten signature]

/О.БОЛДБААТАР/



БАЛАНС – ТОДОТГОЛ

(сая.төг)	Тодотгол 2018/12/31
ХӨРӨНГӨ	25,121
Мөнгөн хөрөнгө	1,313
Зээл (цэвэр дүнгээр)	22,599
Хэвийн зээл	21,824
Хугацаа хэтэрсэн зээл	402
Чанаргүй зээл	374
Хэвийн бус зээл	-
Эргэлзээтэй зээл	-
Муу зээл	-
Зээлийн эрсдэлийн сан	(354)
Зээлд хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	540
Бусад актив	208
Үндсэн хөрөнгө	429
Биет бус хөрөнгө	387
ӨР ТӨЛБӨР	11,603
Бондын өглөг	11,000
Хүүгийн өглөг	320
Бусад өглөг	283
ӨӨРИЙН ХӨРӨНГӨ	13,519
Хувьцаат капитал	8,000
Нэмж төлөгдсөн капитал	2,757
Тайлант жилийн ашиг	2,743
Хуримтлагдсан ашиг, алдагдал	19
Нийт өр төлбөр болон өөрийн хөрөнгө	25,121

Өмнөх Удирдах Зөвлөл
 Өөрт тогтоолын Хавсралт
 ТГГОЛ

 lendmn
 V улирал Нийт
 тодотгол) (тодот
 2 790 3

(сая.төг)	IV улирал (тодотгол)	Нийт 2018 (тодотгол)
ХҮҮ, ШИМТГЭЛИЙН ОРЛОГО	2,799.3	7,418.5
Зээлийн шимтгэлийн орлого	2,771.5	7,241.9
Харилцахын хүүгийн орлого	27.8	176.4
Гадаад валютын ханшийн тэгшитгэлийн орлого	-	0.2
САНХҮҮГИЙН ЗАРДАЛ	(356.3)	(591.4)
Хүүгийн зардал	(356.3)	(591.1)
Гадаад валютын арилжааны зардал	-	(0.2)
САНХҮҮГИЙН ЦЭВЭР ОРЛОГО	2,443.0	6,827.1
Зээлийн болзошгүй эрсдлийн сангийн зардал	(80.9)	(339.0)
ЭРСДЛИЙН САНГИЙН ДАРААХ ОРЛОГО	2,362.1	6,488.1
Нийт шимтгэлийн зардал	(341.8)	(979.2)
АНД Системс Тех ХХК-ийн төлбөр	(238.3)	(700.7)
QPAУ Төлбөр	(21.3)	(64.0)
Банкны шимтгэл	(82.2)	(214.5)
ШИМТГЭЛИЙН ДАРААХ ОРЛОГО	2,020.3	5,509.0
Нийт боловсон хүчний зардал	(322.8)	(941.6)
Боловсон хүчний зардал	(258.2)	(849.8)
Ажилчдын урамшуулал	(60.6)	(82.6)
Сургалтын зардал	(4.0)	(9.2)
Үйл ажиллагааны бусад зардал	(790.8)	(1,424.9)
Гэрээ хэвлэлтийн зардал	(16.3)	(33.2)
Зар сурталчилгаа, маркетингийн судалгаа	(481.6)	(772.4)
Аудитын төлбөр, мэргэжлийн үйлчилгээ	(88.5)	(124.0)
Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал	(32.9)	(96.4)
Түрээс	(44.4)	(106.4)
Даатгал	-	(2.3)
Албан томилолт	(3.0)	(9.8)
Харилцагчдын сургалт судалгааны зардал	-	(4.6)
Баяр ёслол/ Зочин төлөөлөгчийн зардал	(21.8)	(34.8)
Харилцаа холбоо, интернет	(6.6)	(19.6)
Бичиг хэргийн зардал	(5.6)	(11.5)
Бусад	(90.1)	(209.8)
Нийт зардал	(1,113.6)	(2,366.4)
ТАТВАРЫН ӨМНӨХ АШИГ	906.7	3,142.5
Татварын зардал	(168.0)	(399.4)
ЦЭВЭР АШИГ	738.7	2,743.1

“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2018 оны 10 дугаар сарын 24-ны өдөр

№ ¹⁸.../28

Улаанбаатар хот

Компанийн үйл ажиллагааны чиглэл нэмэх тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани” гэх)-ийн дүрмийн 9.6.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс **ТОГТООХ нь:**

1. ЛэндМН ББСБ ХК-ийн үндсэн үйл ажиллагааны чиглэлд итгэлцлийн үйлчилгээний үйл ажиллагааг нэмсүгэй.
2. Компанийн шинээр үйл эрхлэх үйл ажиллагаатай холбоотой холбогдох зөвшөөрлийг Санхүүгийн Зохицуулах Хороо болон бусад эрх бүхий байгууллагаас авах ажлыг зохион байгуулахыг Гүйцэтгэх захирал (Б.Дэлгэржаргал)-д үүрэг болгосугай.



ТУЗ-ИЙН ДАРГА:

..... /О.БОЛДБААТАР/